

Эзлэхүүнт төлөвлөлт хүрээний мэргэшсэн архитекторын зэрэг горилох ур чадварын шалгалт зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж

Нэг. Зорилго

Тухайн үйл ажиллагааны удирдамжийн зорилго нь эзлэхүүн төлөвлөлт хүрээний МЭРГЭШСЭН АРХИТЕКТОР зэрэг горилох архитекторуудыг хамруулан ур чадварын шалгалтыг зохион байгуулах, шалгахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Эзлэхүүн төлөвлөлтийн хүрээнд мэргэшсэн архитекторын зэрэг горилох нэгдүгээр шат буюу тестийн шалгалтад тэнцсэн шалгуулагч хамтадна.

Гурав. Зохион байгуулагчид

Хот төлөвлөлт, барилга архитектур төлөвлөлт, хот төлөвлөлтийн эдийн засагчийн хүрээнд мэргэшлийн зэрэг олгох, сургах шалгалтын комисс шалгалтын материалыг боловсруулан шалгана.

Дөрөв. Хугацаа

Ур чадварын шалгалт үргэлжлэх хугацаа: 240 мин

Тав. Үйл ажиллагааны дараалал

Ур чадварын шалгалтыг дараах байдлаар зохион байгуулна.

5.1 Ур чадварын шалгалтын материалд тавигдах шаардлага

Ур чадварын шалгалтыг танхимаар авах ба өгөгдсөн сэдвийн хүрээнд эскиз /клаузур/ боловсруулна. Шалгуулагч нь эскиз боловсруулахад хэрэгтэй цаас, хэрэглэлийг бэлдэж шалгалтад орно.

Шалгуур үзүүлэлт:

- АЗ хэмжээтэй калькан цаасан дээр гараар зурж боловсруулна.
- Эскиз зураг дараах бүрдэлтэй байна
 - Ерөнхий төлөвлөгөө /Өгөгдсөн газар дээр/
 - Үзэл санаа
 - Байгуулалт
 - Огтлол
 - Нүүр талууд
 - Харагдах байдал
 - Тайлбар бичиг
 - Бусад

5.2 Ур чадварын шалгалтын материал үнэлж дүгнэх:

Шалгалтыг 100 хүртэл оноогоор дүгнэж, хөрвүүлэн тооцно.

Үүнд:

- Ерөнхий төлөвлөгөө /Өгөгдсөн газар дээр/-10 оноо
- Үзэл санаа-20 оноо
- Байгуулалт-10 оноо
- Огтлол-10 оноо
- Нүүр талууд-10 оноо
- Харагдах байдал -10 оноо
- Тайлбар бичиг-20 оноо
- Бусад -10 оноо

Зургаа: Ур чадварын шалгалтын сэдэв

Ур чадварын шалгалтыг 3 өөр хувилбараар боловсруулж, шалгалт өгөгч шалгалт эхлэхээс өмнө сугална.